

# **АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙГ ХААХ, ЗАМЫН ЧИГЛЭЛ ӨӨРЧЛӨХ ЖУРАМ**

## **НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1. Монгол улсын нутаг дэвсгэр дээр байгалийн гамшгийн улмаас авто замын байгууламж хаагдаж боогдсон, эвдрэл гэмтэл гарсан, засвар шинэчлэлт хийх үед авто тээврийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор олон улсын болон улс, орон нутгийн чанартай авто зам, замын байгууламжийг хэсэгчлэн буюу бүтэн хаах, чиглэлийг өөрчлөх, түр замаар явуулахад /цаашид авто замыг хаах, чиглэл өөрчлөх гэнэ/ “Авто замын тухай хууль”-ийн дагуу тодорхой хугацаанд хязгаарлалт, зохицуулалт хийхэд, энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол улсын нутаг дэвсгэр дээр авто зам, замын байгууламжийг ашиглаж байгаа гадаад улсын тээврийн хэрэгсэлд энэхүү журам нэгэн адил хамаарна.

1.3. Хүн, малын гоц халдварт өвчин, гал түймрийн аюул, байгаль цаг уурын давагдашгүй гэнэтийн хүчин зүйлээс бусад тохиолдолд Авто замын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д “Авто зам, замын байгууламж болон авто тээврийн хөдөлгөөнд аюул учирч болох нөхцөл байдал үүссэн, тээврийн хэрэгсэл зорчих боломжгүй болсон авто замд засвар хийх зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд авто замыг түр хугацаагаар хааж болно” гэж заасны дагуу олон улс, улсын чанартай авто зам, замын байгууламжийг хаах буюу чиглэл өөрчлөх шийдвэрийг Авто зам, замын байгууламжийн засвар, арчлалт, хамгаалалтыг хариуцсан байгууллага нь авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр гаргана.

1.4. Хүн, малын гоц халдварт өвчин, гал түймрийн аюул, байгаль цаг уурын давагдашгүй гэнэтийн хүчин зүйлээс бусад тохиолдолд орон нутгийн чанартай авто замыг хаах, чиглэл өөрчлөх шийдвэрийг тухайн орон нутгийн онцгой комиссын шийдвэрийг үндэслэн авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн аймаг, нийслэлийн Засаг дарга гаргана.

1.5. Хүн, малын гоц халдварт өвчин, гал түймрийн аюул, байгаль цаг уурын давагдашгүй гэнэтийн хүчин зүйл болсон тохиолдолд олон улс болон улс, орон нутгийн чанартай авто замыг хаах, чиглэл өөрчлөх тушаалыг Улсын онцгой комиссын шийдвэрийг үндэслэн авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гаргана.

1.6. Олон улсын болон улс, орон нутгийн чанартай авто зам, замын байгууламжийг хаах тухай тушаал гарсан даруйд Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, /Аймаг, нийслэлийн Засаг дарга/ нь олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх үүрэгтэй.

1.7. Авто замын чиглэл өөрчлөх болсон талаарх мэдээллийг уг үйл ажиллагааг эхлүүлэхээс 3-с доошгүй хоногийн өмнө олон нийтийн мэдээллийн хэрэгслээр

зарлаж нийтэд мэдээлнэ. Уг мэдээлэлд тухайн чиглэлийн авто замын чиглэл өөрчлөх шийдвэр хэрэгжиж эхлэх болон дуусгавар болох сар өдөр тодорхой байх шаардлагатай.

1.8. “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг тухай” хуулийн 8.2.2-т “замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор замын хөдөлгөөнийг зохион байгуулах, урсгал, чиглэлийг түр өөрчлөх, хязгаарлах, хаах” гэж заасны дагуу Замын цагдаагийн алба нь олон улсын болон улс, орон нутгийн чанартай авто замыг хэсэгчлэн болон бүхэлд нь хаах, чиглэл өөрчлөх тухай тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллана.

1.9. Зам хариуцагч байгууллага нь авто замыг хаах, чиглэл өөрчлөх шийдвэрийг орон нутгийн удирдлага, тээвэр, авто замын байгууллага, Замын цагдаагийн алба, Мэргэжлийн хяналтын газар болон Онцгой байдлын газарт шуурхай мэдэгдэж, түр зам гаргах, тэмдэг, тэмдэглэгээг тавих болон, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажлыг шуурхай зохион байгуулж ажиллана.

1.10. Хүн, малын гоц халдварт өвчин, гал түймрийн аюул, байгаль цаг уурын давагдашгүй гэнэтийн хүчин зүйлээс шалтгаалан олон улсын болон улс, орон нутгийн чанартай авто зам, замын байгууламжийг хаах тухай зам, тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаал гарсан даруйд улс хооронд болон хот хоорондын нийтийн тээвэрлэлтэд ажиллаж буй тээвэрлэгч нь зорчигчдын аюулгүй байдлыг хангах үүднээс хамгийн ойр сум суурин газарт хүргэж, зохих арга хэмжээг авна.

1.11. Энэхүү журмын 1.10 дахь заалтыг автотээврийн асуудал хариуцсан эрх бүхий байгууллага холбогдох зохион байгуулалтын арга хэмжээ авах ба даатгалын байгууллагатай хамтран гэрээний үндсэн дээр нөхөн төлбөрийг гаргуулж, тээвэрлэгчид олгоно.

## **ХОЁР. АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙГ ХААХ**

2.1. Хүн, малын гоц халдварт өвчин, гал түймэрийн аюул, байгаль цаг уурын давагдашгүй гэнэтийн хүчин зүйлээс бусад үед авто зам, замын байгууламжийг дараах нөхцөлд түр хааж хугацааг нь тогтооно. Үүнд:

2.1.1. Авто зам, замын байгууламж дээр уулын чулуулгийн нуралт үүсэх бодит аюул бий болсон,

2.1.2. Зам, гүүр их хэмжээгээр эвдэрч, яаралтай засварлах шаардлагатай болсон,

2.1.3. Богино хугацаанд цэвэрлэх боломжгүй их хэмжээний цас орж зам, даваа хаагдаж халтиргаа гулгаа үүссэн,

2.1.4. Олон улсын болон улсын чанартай авто зам, замын байгууламжийн засвар, арчлалтын ажлыг гүйцэтгэх үед хэсэгчлэн.

2.1.5. Зам, гүүрийн барилга, их засвар шинэчлэлтийн ажлын үед гүйцэтгэгч компани гэрээнд заасны дагуу түр замыг барьж тухайн замаар тээврийн хэрэгсэл аваар осолгүй орчих нөхцөлийг бүрдүүлнэ. Зам хариуцагч болон Зөвлөх компаниудын хүсэлтийг үндэслэн тухайн зам, гүүрийг улсын ашиглалтад орох хүртэл түр хугацаагаар хаах зөвшөөрөлийг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.

2.2. Авто зам, замын байгууламжийг хаах тухай тушаал гарсан тохиолдолд зам хариуцагч байгууллага Авто замын засвар, арчлалтын техникийн шаардлагын дагуу түр зам, гарцуудыг гаргаж, авто замын орох гарах хэсэгт болон хүндрэлтэй хэсгүүдэд тэмдэг, тэмдэглэгээ тавьж замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангана.

## **ГУРАВ. АВТО ЗАМЫН ЧИГЛЭЛИЙГ ӨӨРЧЛӨХ**

3.1. Авто зам, замын байгууламж тодорхой хугацаагаар хаагдсан шийдвэр гарсан тохиолдолд мөн авто замын шинэчлэлт болон шинээр зам барих үед тухайн хэсгээр түр зам гаргах боломжгүй үед замын чиглэлийг өөрчилнө.

3.2. Авто замын өөрчлөгдсөн чиглэлд тэмдэг, тэмдэглэгээ тавих, орц, гарц гаргаж замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүргийг тухайн Зам хариуцагч байгууллага хүлээнэ. / Орон нутагт зам, тээврийн асуудал хариуцсан байгууллага/

## **ДӨРӨВ. БУСАД**

4.1. Олон улс, улс, орон нутгийн чанартай авто замыг хэсэгчлэн болон бүхэлд нь хаах, чиглэл өөрчлөх тухай авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний гаргасан тушаалыг цаг тухайд нь хэрэгжүүлээгүйн улмаас гарах хохирлыг тухайн байгууллага хариуцан “Зөрчлийн тухай” хуульд заасны дагуу хариуцлага хүлээнэ.

4.2. Олон улс, улс, орон нутгийн чанартай авто замыг хэсэгчлэн болон бүхэлд нь хаах, чиглэл өөрчлөх тухай авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн /аймаг нийслэлийн Засаг дарга/-ийн гаргасан тушаалыг биелүүлээгүй хувь хүн болон хуулийн этгээд нь “Зөрчлийн тухай” хуульд заасны дагуу хариуцлага хүлээнэ.

4.3. Авто зам, замын байгууламжийг хаах, чиглэл өөрчлөх үйл ажиллагаанд энэ журам болон бусад хууль тогтоомжийн дагуу Мэргэжлийн хяналтын газар, Авто зам болон автотээврийн үйл ажиллагаа хариуцсан байгууллага мөн Замын цагдаагийн газар хяналт тавина.

## **АВТО ЗАМЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗАР**